



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай хамгаалалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, нийт 641,924,449.65 (зургаан зуун дөчин нэгэн сая есөн зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун дөчин есөн төгрөг жаран таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 192,577,334.90 (нэг зуун ерэн хоёр сая таван зуун далан долоон мянга гурван зуун гучин дөрвөн төгрөг ерэн мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Зэвсэгт хүчний жанжин штабт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, бригадын генерал С.Ганбямба, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Л.Алтангэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001228

6-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 21 дугаар сарын 27-ны өдрийн  
27... дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ,  
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ (автомашин)-ИЙН ЖАГСААЛТ

| Д/д      | Автомашинны нэр, марк, улсын дугаар, арлын дугаар       | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо | Нийт гүйлт /км/ | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Хэм жиж нэгж | Тоо шир хэг | Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг) |                         |                   |
|----------|---|--------------------------------------|-----------------|-------------------------|--------------|-------------|---|-------------------------------|-------------------------|-------------------|
|          |   |                                      |                 |                         |              |             |   | Цаашид ашиглах жил            | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт үнэ (төгрөг) |
| 1        | Ландкрийер-100, 14-32 УНУ (арал-jeht05j202108891)       | 2007/2007                            | 209757          | 92,474,449.65           | ш            | 1           | 92,474,449.65                                     | 2                             | 27,742,335              | 27,742,334.90     |
| 2        | Мерседес бенз S 350, 03-19 УБГ (арал-wddng56x17a130933) | 2007/2007                            | 102236          | 183,150,000.00          | ш            | 1           | 183,150,000.00                                    | 3                             | 54,945,000              | 54,945,000.00     |
| 3        | Мерседес бенз S 350, 12-68 УНУ (арал-wddng56x87a118181) | 2007/2007                            | 101832          | 183,150,000.00          | ш            | 1           | 183,150,000.00                                    | 3                             | 54,945,000              | 54,945,000.00     |
| 4        | Мерседес бенз S 350, 07-35 УНУ (арал-wddng56x57a110605) | 2007/2007                            | 87974           | 183,150,000.00          | ш            | 1           | 183,150,000.00                                    | 3                             | 54,945,000              | 54,945,000.00     |
| Нийт дүн |   |                                      |                 |                         |              |             | 641,924,449.65                                    |                               |                         | 192,577,334.90    |